



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

┌ Журам болон аргачлал батлах ┐
тухай

/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалуудыг батлах тухай/

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ыг 1 дүгээр, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал”-ыг 2 дугаар, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал”-ыг 3 дугаар, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.


2. Батлагдсан журам, аргачлалыг хэрэгжүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсүүдэд хүргүүлэн мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т үүрэг болгосугай.

3. Холбогдох гарын авлага, маягт, сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрийг 2019 оны 03 дугаар сарын 01-ний дотор багтаан боловсруулж, бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагчид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, холбогдох сургалтуудыг зохион байгуулахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т даалгасугай.

4. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг 2020 оноос эхлэн энэхүү батлагдсан журам, аргачлалын дагуу хэрэгжүүлэхийг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагчид, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн холбогдох хэсгийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, цахим системийн хамгаалалтыг хариуцан, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /С.Дорждагва/-т, Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т тус тус даалгасугай.

6. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус үүрэг болгосугай.



Ч.ХҮРЭЛБААТАР